



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

СОНССОН НЬ: АСУУДАЛ

Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авахыг түр зогсоох тухай тогтоолын төслийг Үнэт цаасны газрын Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын хэлтсийн дарга А.Авир танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: АСУУДАЛ

1. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авахыг түр зогсоох тухай асуудлыг хэлэлцээд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгохоор тогтов:

1/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсонтой холбогдуулан хийгдэх бэлтгэл ажлын хүрээнд цаашид мэргэжлийн зуучлагч байгууллагуудад тавигдах шалгуурыг өөрчлөх зайлшгүй шаардлагын дагуу түүнд нийцүүлэн дүрэм, журам, зааврыг боловсруулах;

2/ Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авахыг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар түр зогсоох;

2. Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж, шийдвэрийн төслийг Хорооны хуралдаанд эргэж танилцуулахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгахаар тогтов.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000062